



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/119

Цагаантолгой

Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.11, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.8, 9.9, Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2022 оны “Бруцеллэзын дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” А/166 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/329 тоот захирамж, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын “Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай” А/19 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч : А.Одхүү (Засаг даргын Тамгын газрын дарга )  
Гишүүдэд- Г.Анхбаяр (/Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)  
Б.Золбаяр (2-р багийн Засаг дарга)  
Л.Сэлэнгэсайхан (1-р багийн Засаг дарга)  
О.Лхагвасүрэн (Сантбаянхайрхан МЭҮН-н захирал)  
Ө.Ганбаатар (Бошгын булаг ХХК-н захирал)

2.1. Дархлаажуулах ажлыг 2020 оны 08 сарын 18-ны өдрөөс 09-р сарын 07-ныг өдрийг хүртэл хугацаанд шуурхай, чанартай зохион байгуулсугай.

2.2. Дархлаажуулалтанд адуунаас бусад мал сүргийн охин төлийг вакцинжинжуулаад илүү гарвал эр төлөө тарьж вакциныг дуусгана.

2.3. Вакцинжуулалтын ажлыг зохион байгуулахдаа бруцеллэз өвчинтэй тэмцэх стратеги төлөвлөгөөний дагуу бруцеллэзын өвчний вакцин тарих стандарт зөвлөмж зааврыг чанд мөрдөхийг ажлын хэсэгт даалгасугай.

2.4. Дархлаажуулах ажлаас малаа хоцроосон, зайлсхийсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хариуцлагагүй хандсан албан тушаалтанд хуулийн дагуу арга хэмжээ авах, хариуцлага тооцох хяналт тавьж ажиллах.

3. Дархлаажуулалтанд малчин өрхийн мал бүрийг бүрэн хамруулах ажлыг багийнхаа хэмжээнд зохион байгуулж, иргэдэд мэдээлэл сурталчилгаа хүргэн ажиллахыг багийн Засаг дарга /Л.Сэлэнгэсайхан, Б.Золбаяр / нарт үүрэг болгосугай.

Аймгийн Засаг дарга

С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *С. Ахмедов*  
Хянасан: *Ч. Ахмедов*  
Хувь: *2*  
Огноо: *2022 09 06.*